



ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТББ

Энэхүү сонин бичгийг “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн мониторинг ба хараат бус хэвлэл мэдээллийн эрхийг дэмжих нь” төслийн хүрээнд “Глоб Интернэшнл” ТББ-аас 2 сар тутамд эрхлэн гаргана.

Энэ дугаарт

Танд сонирхуулахад

Уншигчдын оролцоотойгоор сонины борлуулалтыг нэмэгдүүлэх нь

Хоёрдугаар нүүр

Өвөөгийн жор

Дууриахуйн ухаан

Гурав, дөрөвдүгээр нүүр

Хуульч зөвлөж байна

Нууцын тухай зах зухаас нь

Тавдугаар нүүр

Тэд сонины тухай

Сонины үүрэг /Дэлхийн сонинуудын холбоо/

Тайлбар, дүн шинжилгээ бол сонины давуу тал

Зургадугаар нүүр

Өөрийгөө зохицуулах нь

Сэтгүүлчдэд зориулсан зөвлөмж /Финлянд/

Долдугаар нүүр

Далайд дусал

Бүтээгдэхүүнээ сайжруулах нь

Наймдугаар нүүр

Сонин бичгийг онлайн болон хэвлэмэл хэлбэрээр авч унших сонирхолтой хүмүүс дараах хаягаар холбоо барина уу.

Манай хаяг: Соёлын төв өргөө, Г корпус, 3 давхар, Улаанбаатар 210620-А, Ш/х-28

Утас: Э-шуудан
324627 globe@magicnet.mn
324764 globe@globeinter.org.mn
99276253 garav@globeinter.org.mn
bayan@magicnet.mn

Редакцийн зөвлөл:

- Д.Мөнхбүрэн
- Г.Нарангарав
- Х.Цэвэлээ

ТЕЛЕВИЗИЙН СЭТГҮҮЛЧИД ХАЛДЖЭЭ

Орхон аймгийн “Номин” телевизийн редактор, сурвалжлагч Бямбадоржийн Цэвэгмидийг 2006 оны 07-р сарын 06-ны шөнийн 24 цагийн орчимд гэрийнх нь оронд үл мэдэгдэх хүмүүс төмөр трубагаар нуруу, цээжинд нь цохиж, гэмтээгээд зугтжээ. “Номин” телевизийн захирал Баасанжавын ярьснаар сэтгүүлч нэг хавирга нь хугарсан, тархины 1-р зэргийн гэмтэлтэй, нугаснаас ус авах шаардлагатай гэсэн оноштойгоор Орхон аймгийн Гэмтлийн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасагт эмчлүүлж байгаа тухай “Глоб Интернэшнл”ТББ-ын хойд бүсийн мониторингч.

Дэлгэрэнгүйг: <http://www.globeinter.org.mn/newsdetail.php?nid=292>

ОУСХ МЭДЭГДЭЛ ХИЙВ

Монголын телевизийн сэтгүүлчийг зоджээ

Орхон аймгийн “Номин” телевизийн редактор Б.Цэвэгмид 7-р сарын 6-нд гэрийнхээ оронд үл мэдэгдэх этгээдүүдэд зодуулж, гэмтсэний улмаас эмнэлэгт хүргэгдсэн тухай мэдээллийг Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо /ОУСХ/ цочирдон хүлээн авч, эгдүүцэж байна.

ОУСХ-ны Ерөнхийлөгч Кристоффер Варрен хэлэхдээ, “Энэ балмад халдлага нь мөн чанарын хувьд хамгийн ноцтой бөгөөд гэмт этгээдүүдэд зохих шийтгэлийг нь ногдуулах ёстой. Ажил үүргээ гүйцэтгэж байгаа хэн нэгний эрүүл мэндэд халдахыг хүлцэж, хүлээн зөвшөөрөх аргагүй билээ” гэсэн байна.

Дэлгэрэнгүйг: <http://www.globeinter.org.mn/newsdetail.php?nid=297>

ӨМНӨГОВЬ АЙМАГТ СЭТГҮҮЛЧИЙН МЭДЭЭЛЭЛ ОЛЖ АВАХ, ТҮГЭЭХ ЭРХ ЗӨРЧИГДӨЖ БАЙНА

Өмнөговь аймгийн засаг дарга М.Ядмаа 7-р сарын 27-нд болсон Засаг даргын тамгын газрын хэлтсийн дарга нарын хурлыг “Алтан говь” телевизийн зураглаач М.Шинэхүү сурвалжилж байх үеэр цаашид тус телевизэд мэдээлэл өгөхгүй байх үүргийг газар, хэлтсийн дарга нартаа өгчээ.

“Алтан говь” телевиз 07 сарын 26-ны өдрийн мэдээллийн хөтөлбөрөөрөө махны үнэ хэт өсч байгаа тухай мэдээлэхдээ махны худалдагч Долгорын “Аймгийн засаг дарга өөрийн ах дүү нартаа мөнгө гарган өгч өөр аймгуудаас мах авчирч заруулсан” гэсэн утгатай ярилцлагыг оруулжээ.

Дэлгэрэнгүйг: <http://www.globeinter.org.mn/newsdetail.php?nid=309>

ГОВИЙНХАН “АМЕРИКИЙН ДУУ ХОЛОЙ”-Г СОНСОЖ БАЙНА

Өмнөговь аймгийн FM 103,6 радио “Америкийн дуу хоолой” радио станцын нэвтрүүлгүүдийг цацаж эхэллээ. Дээрхи нэвтрүүлгүүдийг цацахад шаардагдах тоног төхөөрөмжийг АНУ-ын Азийн сан, АНУ-ын элчин сайдын яамнаас санхүүжүүлэн суурилуулсан бөгөөд нийт 6 сая гаруй төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Өмнөговь аймгийн сонсогчид Америкийн дуу хоолой радио станцын Дэлхий дахины хамгийн сүүлийн үеийн мэдээ мэдээлэл, англи хэлний хичээлэл, хит дуу хөгжмийг өдөрт 4 удаа тус бүр 20 минутын хугацаатай хүлээн авч сонсож байна. Америкийн дуу хоолой радио станцын нэвтрүүлгийг сансрын хиймэл дагуулаас хүлээн авч 160-180 км-ийн радиуст цацаж байна.

Дэлгэрэнгүйг: <http://www.globeinter.org.mn/newsdetail.php?nid=338>

ТЕЛЕВИЗИЙН СЭТГҮҮЛ ЗҮЙН ШИНЭ НОМ ХУДАЛДААНД ГАРЛАА



Монголд урьд өмнө гарч байгаагүй телевизийн сэтгүүлчдэд зориулсан “Телевизиийн сэтгүүл зүй” гарын авлага хэвлэгдэн гарлаа. Энэ номонд телевизийн тухай ойлголт, хэв шинж, төрөл хэлбэрийн талаар мөн телевизийн сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааны онцлог, оролцоо болоод нэвтрүүлэг бэлтгэх арга ажиллагаа төрөл хэлбэрийн талаарх ойлголт, практик зөвлөмжүүдийг онол туршлагад тулгуурлан дэлгэрэнгүй өгүүлжээ. Үүнээс гадна телевизийн нэвтрүүлгийн бүтэц, бүрэлдэхүүн, дэлгэцийн хэл, түүний арга, элементүүдийн талаар та энэ номноос унших боломжтой.



Танд сонирхуулахад

Сэтгүүлч, сонины ажилтнууд өөрсдийн сонины захиалга, борлуулалтыг хэрхэн нэмэгдүүлэх талаар бусдын арга туршлагаас суралцах, судлах сонирхолтой байдаг нь сэтгүүлдийн дунд явуулсан “Сонин бичиг”-ийн нийтлэлийн талаарх судалгаанаас тодорхой байна. Иймээс энэ удаагийн дугаарт Дэлхийн сонинуудын холбооны “Шинэ агуулга дэвшил” илтгэлээс товчлон орчуулж нийтэллээ.

УНШИГЧДЫН ОРОЛЦООТОЙГООР СОНИНЫ БОРЛУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

Сонины тоо ширхэгийг жилд 1000-2000 хувь нэмэгдүүлнэ гэдэг өнөө үед ямар ч сонины хувьд амаргүй даваа юм. Шведийн “Сидсвенска Дагбладет” сонин 1992 оноос сониныхоо тоо ширхэгийг нэмэгдүүлж чаджээ. Энэ бүхнийг хэрхэн хийсэн бэ? Тус сонины эрхлэгч Ян Вифстрандын ярьснаар сонины агуулгад уншигчдыг татан оролцуулахад түлхүү анхаарсан байна.

Вифstrand болон түүний багийнхан сонины агуулгыг боловсруулахад зах зээлийнхээ бүх бүлгийн уншигчдыг татан оролцуулсан аж. Гэхдээ тэд залуучууд, цагаач иргэд гэх мэт сонирхлыг нь татахад төвөгтэй уншигчдыг урвуулахад онцгой их хүчин чармайлт гаргажээ.


“Зурагтыг хүлээтэй юм шиг үздэг залуучуудыг татахад хэцүү гэж бид итгэлтэй хэлдэг. Гэтэл тэдэнд боломж олговол татан оролцуулах боломжтой” гэж тэрээр нэмж хэлэв.

Үүний нэг сонгодог жишээ бол 17-оос доош насны хүүхдүүдийн илгээсэн захидалд тулгуурлан 25 жилийн турш эрхлэн явуулж байгаа өдөр тутмын булан юм. “Сидсвенска Дагбладет” сонин өсвөр насны хүүхдүүдээс маш олон захидал хүлээж авдаг бөгөөд тус сонин сүүлийн таван жилд ирсэн бүх захидлыг багтаасан сар тутмын хавсралт сонинг эрхлэн гаргаж байна. Залуучуудыг татах бодитой алхмын өрдөө нэг арга нь энэ юм. Үүнээс гадна сонины энэ буланд байгаль орчин, үр хөндөлт, архидалт, рок хөгжим, нийгмийн бусад тулгамдсан асуудлууд зэрэг тэдний сонирхлыг татах сэдвээр хэлэлцүүлэг явуулдаг. Сонины энэ булан зөвхөн 17-оос доош насныхны захидлыг хүлээж авдаг байна. Энэ буланд шинэ үг хэллэг, илэрхийлэл ашигласан богино захидлыг илүүтэй нийтэлдэг. “Сонины хэлэлцүүлэг бүхий хамгийн сонирхолтой, амьдралтай хэсэг нь энэ булан байдаг” гэж тэрээр онцлон дурдлаа.

Тус сонин сард дунджаар 500-600 захидал, е-мэйл хүлээн авдаг. Дээрх уншигчдын дийлэнх нь захидлаа вэб хуудаснаас илүүтэйгээр сонинд тавих сонирхолтой байдаг нь судалгаанаас харагдаж байна. “Энэ бол их сайн үзүүлэлт. Эдгээр уншигч тусдаа гарсан хойноо өөрсдийнхөө мөнгөөр сонингоо захиалан уншаар байна гэсэн үг” хэмээн Вифstrand үзэж байна.

Захидлаа сонинд хэвлүүлэх сонирхолтой хүмүүс зөвхөн 17-оос доош насныхан биш гэнэ. Сонины редакторт хаягласан захидлыг нийтэлснээр насанд хүрэгчдийг ч гэсэн татах чухал арга юм. “Уншигчид хэлэлцүүлэгт оролцох хүсэлтэй байдаг. Хүмүүсийг татан оролцуулна гэдэг нь тэдний үзэл бодлыг хүндэтгэнэ гэсэн үг бөгөөд телевиз, радиогийн нэвтрүүлэгээр олонтаа ажиглагддаг уншигчдын үзэл бодлыг үл ойшоох явдал гаргаж хэрхэвч болохгүй юм. Сонинд зөвхөн уншигчдын захидлын булан чухал биш, үүнийг дараах байдлаар ойлгох хэрэгтэй. Тодорхой хугацаанд хамгийн шилдэг захидлыг шалгаруулан сонины нүүр хуудаст нийтэлж эхэлнэ. Үүнээс гадна одоо болон яваандаа бид захидал хариуцсан редакторын булан гэж ажиллуулна. Энэ буланд тэрээр хамгийн чухал асуудлуудыг хөндөнө. Ирсэн захидал болгоныг бид нийтлэх боломжгүй. Тиймээс бид тодорхой шалгуураар хянан тохиолдуулдаг. Бусад сонинг бодвол бид уншигчдын захидалд дөрвөөс тав

дахин их зай гаргаж, 5-6 дахин их хүн ажиллуулдаг” гэж тэрээр ярилаа. Өөр нэг чухал зүйл бол цагаач, дүрвэгч иргэдийг татахад цаг зав, хүч хөдөлмөр зарцуулахыг эрмэлздэг. Бусад сонинууд үүнийг төдийлөн хайхардаггүй нь санхүү болон хэлний бэрхшээл, тэдний сонин унших давтамж хангалтгүй, олон үндэстэнг нэгтгэхэд хүнд байдаг зэргээс улбаатай байж болох юм. Ийм хүнд сорилуудыг даван туулахаас зүрхшээж байвал ирээдүйгээ харж чадахгүй байна гэсэн үг. Тухайлбал Шведийн Малмо хотод л гэхэд хүн амын 20-25 хувь Босни, Турк, Сомали, Ирак зэрэг улсаас ирсэн цагаачид байдаг. Малмо хотын удирдлагууд цагаач иргэдийг илүү их анхаарах болсны д а р а а шинэ уншигчдыг татахын тулд сонингоо 50



хувийн хөнгөлттэй үнээр борлуулдаг уламжлалт аргын оронд бид “Розенгарден” нэртэй хуудас сонинг хэвлэн тараасан юм. Сар бүр гардаг энэ хуудас сонинг 15 мянган өрхөд хүргэсэн байгаа. “Бид тэдний оршин суудаг газрын талаар нийтэлж эхэлснээс гадна энгийн оршин суугчдын дуу хоолойг тусгаж өгсөн нь зөв шийдэл болсон юм. Түүнчлэн орон нутгийнханд зар сурталчилгааг аль болох хямд үнээр тавих боломж олгохыг чармайж байсан.”

Үр дүнгийн тухайд? “Бид саяхан таван жилийнхээ ойг тэмдэглэсэн. Энэ арга хэмжээг зохион байгуулахад бид нэг сая крон буюу 250 мянган доллар зарцуулсан. Энэ бол ирээдүйдээ хийж буй хөрөнгө оруулалт. Энэ арга хэмжээг зохион байгуулснаар манай сонины зар сурталчилгаа, тоо ширхэг нэмэгдсэн үү? Манай сонины борлуулалт 2-3 жилд нэмэгдэх үү? Үгүй. Одоогийн уншигч хүүхдүүд улам их уншиж, хэзээ нэгэн цагт манай сонинг худалдан авах уу? Мэдээж хэрэг тийм. Миний хувьд энэ бол ирээдүйгээ харсан хямд хөрөнгө оруулалт юм.” гэв.

Зарим тохиолдолд сонинууд амин чухал асуудлаас зугтах хандлагатай байдаг. Жишээ нь улс төрийг аваад үзье л дээ. Вифстрандын үзэж байгаагаар ерөнхийдөө сонинууд улс төрийн тактикийн талаар их бичдэг хэрнээ үр дүнгийнх нь талаар төдийлөн дурьддаггүй. “Тухайн мэдээний тал хувьд нь тактикийн талаар дөрөвний нэгд нь үр дүн, үр нөлөөг нь тусгаж өгөх нь зүйтэй” гэж тэрээр зөвлөсөн байна.

Түүнчлэн тэрээр гэрэл зурагийн тухайд ярихдаа “Сонин болгон ялалт байгуулсан тамирчны гараа өргөж, бахдам инээмсэглэсэн гэрэл зургийг тавьсан байдаг их харамсдаг. Хэдийнэ уншигчийн танил болсон энэ дүр төрхийг нийтэлснээрээ тухайн гэрэл зурагчин цаг үеэсээ хоцорч явааг илтгэн харуулж байгаа юм” гээд “Бид гэрэл зургийн сэтгүүл зүйг ч анхааран судалж амьдралд хэрэгжүүлэх хэрэгтэй” хэмээн дүгнэв.

“Буцаж очоод сонингоо сайтар судла. Шинэ зүйлийг нээж өгдөг орон нутгийн нийтлэл өгүүллийг гүн гүнзгий судлахад хэзээ ч алдахгүй гэдгийг хэлбэ. Энэ ажил ямар ч маркетингийн аянаас илүү” хэмээн тэрээр онцлоод “сонинг уншигчдад зориулж гаргадаг гэдгийг ямагт санаж байх хэрэгтэй. Уншигчид сонины агуулгыг ярихаас бус маркетингийн стратеги эсвэл сонины редакцийн талаар ярьдаггүй гэдгийг анхаараарай.”

Бэлтгэсэн: Г.Нарангарав

ДУУРИАХУЙН УХААН

Соёлын гавъяат зүтгэлтэн
Хорлоогийн ЦЭВЭЛЭЭ

ЯАГААД ЗААВАЛ ДУУРИАХ ЁСТОЙ ГЭЖ?

Ямар ч эрдэм чадварыг хэн ч эзэмшиж болно. Тоть шувуу хүртэл үг хэлж сурсан байдаг. Хүмүүн бид төрөхдөө хэлгүй төрөөд хэлд ордог. Үүнээс үүдэн сэхээрвээс сайн бичдэг болохын тулд сайныг дууриах хэрэгтэй гэсэн өөрийн итгэл төрнө. Хэнийг ч дууриахгүй сайн бичдэг болно гэж байхгүй. Өөрийн толгойтой, өөрийн арга барилтай, өөрийн онцлогтой, өөрийн дуу хоолойтой байна гэдэг нь дууриахуйн дараах давааны зорилт.

Баянхонгорын унаган харъяат Даваагийн жаал хүү Дондог байлаа гэхэд "Аавын алаг морь", "Манай багийн засаг дарга" гэж хэлж сурдаг байхад, зах зэргэлдээ Өвөрхангайн Цоцолын хүү Самдан болохоор "Аавын алга морь", "Манай багын засаг дарга" гэж хэлд ордог. Алс баруун аймгийн хүүхэд Эй хөөркэс гээд санаа алддаг байхад, төв нутгийнхан Ай хөөрхий гээд санаа алдах жишээний. Аав ээж нарыгаа дуурайн шулганасаар байгаад нэг л мэдэхэд ийнхүү яг тэд нар шиг ярьдаг монгол хэлтэй хүн болчихно. Тусгайлан хэлний хичээл заалгах албагүй.

Үүнчлэн орос, хятад, герман, япон, солонгос гээд ямар ч хүний үр хар няхаасаа монгол айлд өргөгдөж хэлд орвол өөр өөрийн төрөлх мах цусны хэл гэхгүй зөвхөн монгол хэлтэй хүн болно. Хүн хүнээ дуурайж хэлд орж хүн хүнээ дуурайж амьдардаг учраас өөр аргагүй. Яг үүн шиг сайн бичдэг амьдралчдийг "Дуурайн шулганаад байх" аваас нэгэн цагт тэднээсээ дутуугүй, магадгүй илүү сайн бичдэг болж чадна. Харин анх бичиж сурахад дуурайх, санаа авах зүйл заавал хэрэгтэй. Түүн дээрээ дөрөөлөөд өөрийгөө хөгжүүлж чадвал нэртэй сайн сэтгүүлч зохиолч болох боломж чөлөөтэй.

Хүн бүхэн Моцарт шиг авъяастай төрөх биш. Моцарт ч гэсэн хөгжимчин биш айлын хүүхэд байсан бол 6 настайдаа концерт бичиж чадах байсан эсэхийг хэн мэдлээ. Сайн уран бүтээлийг ажиглаж дуурайх нь сайн уран бүтээлч болоход хэл сурч байгаа хүүхдэд аав ээж нь багш болдог шиг чухал. Дагуулж дуурайлгах зүйл нь сайн байх тусам түүнээс давж бичдэг болоход ач тустай. Өөрийн сайн мэддэг зохиол бүтээлийг хуулбарлаад байлтай биш, харсаар мэдсээр байгаад тэдгээрээс долоон дор юм бичиж нийтлүүлэлтэй биш. Хэрэв түмний доог болохыг хүсээгүй л бол сайн бүтээлийг хуулбарлахгүйгээр түүнд аль болох ойртож, улмаар өөрийн онцлог дуу хоолойгоороо давж гарахаас өөр зам байхгүй. Тиймээс эхлэн бичигчдэд дуурайх зүйлээ сонгож олох нь эхний эрхэм чухал алхам. Миний бодлоор бол нэгэнт олж авсан бүтээлийг наад зах нь гурав дөрвөн удаа нэлээн сайн хянамгай уншихад заримыг нь бүр цээжээр мэддэг болох аваас өмнөхөөсөө огт өөрөөр бичдэг болж чадна.

ХЭН ХЭНИЙГ ДУУРИАХ ВЭ?

Сэтгүүл зүйн сайн бүтээл тоо томшгүй олон тул өөрийн мэдэхээс цөөнийг нэрлэхэд тухайлбал Б.Ринчингийн "Их говийн зоригтон хүмүүс", Мөнгөний Бизъяагийн "Өвлийн нүүдэл" хэмээх найрууллууд, Лодонгийн Түдэвийн "Нью-Йорк-урт цацтай хот" тэмдэглэл, Жадамбын Пүрэвийн "Эрлэг номуу хаан энэ үгийг хэлүүлэх элчээр намайг томилов" тэмдэглэл, Долгорын Нямаагийн "Атлантын түрлэг" ном, Сумъяагийн Жамбалдорж, Эрдэнэцогтын Сонинтогос нарын "Гайхамшиг Франц орон" ном, сэтгүүлч зохиолч Дамбын Цэмбэлийн "Монгол 500 жил наслана" ярилцлага, "Зам чинь зөв бол алхаад бай" ярианы тэмдэглэл, Сүхбаатарын Батмөнх агсны "Өндөр хөх огторгуй" ном, сэтгүүлч зохиолч Рэнцэндоржийн Эмүүжингийн "Алдуурсан он цаг" ном, сэтгүүлч П.Хэрлэнтуяагийн эргэцүүллийн ном зэргийг олж уншвал тустай болно.

Сэтгүүлч, зохиолч Балжирын Догмидын "Улаан тарианы хүүхнүүд", "Сумын даргын эхнэр" уран нийтлэл, Долгорын Цэнджавын "Буурал ээжийнхээ хөлийг хучиж чадлуу" нийтлэл, сэтгүүлч Сүрэнгийн Зэвсэгийн "Ижий уул минь" дурсамжийн нийтлэл, сэтгүүлч Содномдаржаагийн

Батбаатарын "Хаан уулсын эцэг, хатан мөрний ижий нутаг" тэмдэглэл, сэтгүүлч Ш.Цэрэнпилийн "Хэнээт" хэмээх хөрөг, сэтгүүлч, зохиолч Бажуудайн Ганбатын "Эх", сэтгүүлч Т.Бүдээхүүгийн "Хүмүүн" зэрэг эссэнүүд, сэтгүүлч зохиолч Долгорын Чулуунбаатарын "Ялан дийлэхийн ухаан", "Цог хийморийн тууж" хөрөг туужууд, сэтгүүлч Бибишийн Оюун-Эрдэнийн "Хэн нь хэн бэ?" хөрөг тэмдэглэлийн ном зэрэгт уншууртай, санаа сэдэл авч болох өгөөжтэй сайн зүйл их бий.

СЭТГҮҮЛЧИЙН БҮТЭЭЛ ХЭН ШИГ БАЙХ УЧИРТАЙ ВЭ?

Сэтгүүлчийн өвөрмөц онцлог нь сонгон авсан баримтын өнгөн дээр илэрдэг. Хорвоо дээр оршин байгаа бүхэн баримт. Баримт бүхэн өөрийнхөө хэлээр ярьдаг. Нэг баримт түмэн янзаар ярьдаг. Жишээ нь, эх хүн бол ерөнхий утгаараа адилхан л эх хүн. Гэвч эхийн тухай хичнээн олон янзаар бичсэн байдаг билээ. Түүн шиг эх орон, эмээлт хүлгээ хараад монгол хүн ямар олон сайхан бүтээл туурвисан билээ. Цаана нь бидний мэдэхгүй нь ч их бий. Цаашид энэхэн хоёр баримтат сэдвээр гэхэд хичнээн мянга түмэн алдартай сайхан бүтээл туурвил бүтээж болохыг хэлж барахгүй.

Ийнхүү ертөнцийн өгөгдөл бүхнээс шинэ шинэ утга авцалдаа онгичиж олохыг би хувьдаа баримт буйлуулах эрдэм гэж нэрлэж байгаа. Үүний хамт баримт галзууруулах, баримт хагсаах, баримт живхрүүлэх, баримт сойх, баримт төнхөх, баримт боловсруулах гэхчлэн утга нь дүйх олон хэллэг байж болох юм.

Хорвоод хоорондоо яг адилхан хүн байдаггүй. Үүн шиг сэтгүүлчдийн бүтээл өөр өөр өө. Сайн бүтээл бичсэн эзэнтэйгээ адилхан байдаг юм гэсэн. Нэгэнт сонгон авсан баримтан дээрээ тогтож ажиллахад хэн гуай ч таныг албадаагүй, үүрэгдээгүй, шан харамж амлаагүй, хэнд ч урьдчилан үзүүлээгүй, санал зөвлөмж аваагүй, өөрт төрсөн сэтгэлийг элдэв хэв загварт оруулах гэж зовоохгүй зоргонд нь тавьж бичвэл тэр бүтээл тантай адилхан бүтээл болно. Мөнөөх сургуулийн танхимд адилхан заалгасан онол практик, дууриах гэж мэрийн шамдаж уншдаг байсан олон арван бүтээлүүд чинь ор мөргүй алга болсон байх болно. Яагаад гэвэл хүний идсэн сайхан хоол мах цус, уураг тархи болоод биенд шингэдэг шиг оюун ухаанд чинь шингээд авъяас чадвар болон хувирчихсан байх тул ялгаж харах аргагүй юм.

Сэтгүүлчийн өвөрмөц онцлог баримтын өнгөн дээр илэрдэг. Хорвоо дээр оршин байгаа бүхэн баримт. Баримт бүхэн өөрийнхөө хэлээр ярьдаг. Нэг баримт түмэн янзаар ярьдаг. Жишээ нь, эх хүн бол ерөнхий утгаараа адилхан л эх хүн. Гэвч эхийн тухай хичнээн олон янзаар бичсэн байдаг билээ. Түүн шиг эх орон, эмээлт хүлгээ хараад монгол хүн ямар олон сайхан бүтээл туурвисан билээ. Бидний мэдэхгүй нь ч их бий. Цаашид энэхэн хоёр баримтат сэдвээр гэхэд хичнээн мянга түмэн алдартай сайхан бүтээл туурвил бүтээж болохыг хэлж барахгүй жишээний.

Ийнхүү ертөнцийн өгөгдөл бүхнээс шинэ шинэ утга авцалдаа онгичиж олохыг би баримт буйлуулах эрдэм гэж нэрлэж болно. Үүний хамт баримт галзууруулах, баримт хагсаах, баримт живхрүүлэх, баримт сойх, баримт төнхөх, баримт боловсруулах гэхчилэн утга нь дүйх олон хэллэг байж болох юм.

Хорвоод хоорондоо яг адилхан хүн байдаггүй. Үүн шиг сэтгүүлчдийн бүтээл өөр өөр байх учиртай. Сайн бүтээл бичсэн эзэнтэйгээ адилхан байх ёстой. Нэгэнт сонгон авсан баримтан дээрээ тогтож ажиллахад хэн гуай ч таныг албадаагүй, үүрэгдээгүй, шан харамж амлаагүй, хэнд ч урьдчилан үзүүлээгүй, санал зөвлөмж аваагүй, өөрт төрсөн сэтгэлийг элдэв хэв загварт оруулах гэж зовоохгүй зоргонд нь тавьж бичвэл тэр бүтээл тантай адилхан бүтээл болно. Мөнөөх сургуулийн танхимд адилхан заалгасан онол практик, дууриах гэж мэрийн шамдаж уншдаг байсан олон арван бүтээлүүд чинь ор мөргүй алга болсон байх болно.

Яагаад гэвэл хүний идсэн сайхан хоол мах цус, уураг тархины тэжээл болоод биенд шингэдэг шиг оюун ухаанд чинь шингээд авъяас чадвар болон хувирчихсан байх тул ялгаж харах аргагүй юм.

БИЧГИЙН ЗАСАГЛАЛ ХЭМЭЭХ НЬ ЯМАР УЧИРТАЙ ВЭ?

Би уран зохиолч биш. Дипломтой сэтгүүлч ч биш. Зөвхөн голомттой нэгэн уншигч. Сэтгүүл зүйн бүтээл шиг баримт мэдээлэл сайтай, уран зохиол шиг сэтгэл дэвэлзүүлсэн, сайхан зүйл уншихыг хүсдэг тэр хүслээрээ л залуустаа зарим зүйл зөвлөж байна.

Сэтгүүлч зохиолч нөхдийн туурвин бүтээдэг ном судар, сонин бичиг бол мэдээлэл дохионы хэрэгсэл төдийхөн биш бусдыг амьдралын аливаа сайн үйлд дуудаж, хөтлөн дагуулдаг үгийн засаглал мөн юм. Үг бол нэгний оюун ухаан гадагшилж нөгөөгийндоо гийчлэн засаглах тахар (цагдаа) хэмээн бүдүүвчилж болно.

Ингээд бодохоор сэтгүүлчдийн бичлэг бүхэн үгс. Бичлэг бүхэн засаглал. Бичлэг бүхэн ухаан. Бичлэг бүхэн сэтгүүлчийн зүрх сэтгэлийн элч байдаг учиртай. Монголчууд биднийг нийтээр нь хүмүүнлэг сайхан сэтгэлтэй, зөв мэргэн ухаанаар эв найртай амьдардаг болон засаглах их хүч юу юунаас түрүүн утга бичгийн соёлыг зууцилж дамжуулдаг сэтгүүлч зохиолч нарын авъяас билиг, мөс жудаг, зүрх сэтгэлд оршин байдаг.

Бичгийн засаглалыг хэрэгжүүлэх оньсон түлхүүр нь нийтлэл бүхнийг уншигдахаар бичиж чадах ур чадвар. Үүний тулд бичих ур чадварын өндөр түвшинд хүрсэн үлгэр жишээ бүтээлүүдээс санаа сэдэл авч суралцах нь хувийн үзэмжийн асуудал биш нийгмийн бодит шаардлага мөн.

НЭВТРЭХ ЧАДВАР

Хэвлэл мэдээллийг дөрөв дэх засаглал гэж нэрлэх болсон нь дөрөвдүгээр зэргийн байр эзэлдэг засаг гэсэн утга бус хааныг ч хаанчилдаг бүхний хаан гэсэн утгатай гэж ойлговол зохино. Хаанд ч тус болохын тулд түүний дотоод ертөнцөд нь нэвтрэх ур чадвар эзэмших нь чухал аа. Хэвлэл мэдээлэлд “Нэвтрэх чадвар” гэж нэг юм бий. Түүнийг хүмүүст уншигдаж таалагдах урлаг гэсэн ч болох. Эрин цагийн эрэлт хэрэгцээнд нийцэж байх гэсэн утгатай юм.

Орчин үеийн асар их мэдээлэлжсэн уншигчийн зүрх сэтгэлд амжиж нэвтрэх гэдэг тун амаргүй. Өөрөө сайн мэдээлэлж тэр дотроо өөрөө шургаж орох хэрэгтэй. Иймээс сүүлийн үед дотоод бясалгалын утга зохиол илүү уншигддаг боллоо. Аливааг өөрийн дотоод сэтгэлээс гарган бараг санаанд оромгүй уран чадварлаг өгүүлж чадсан л бол бусдын сэтгэлд нэвтрэх сэтгэлийг нь шинэтгэж, ухааныг тэлж өөрийг нь өөрчлөн өөдлүүлэх нь мэдээж.

Цаг үе бүхэн өөртөө тохирсон өвөрмөц эрэлт хэрэгцээтэй. Өнөөдөр хорин нэгдүгээр зууны эхэн үе. Түүнд өөрийн эрэлт хүсэлт гэж нэг бодитой юм байна. Тэр эрэлт нь бүхнийг сүлэлдүүлж сорчилж ашиглах хандлага юм.

Зожирон салах, тусгаарлан бие даах хөдөлгөөний хурд саарч, сүлэлдэн нийлэх эрин үе ирснийг хүн төрөлхтөн зөнгөөрөө мэдэрч байна. Орчин цагийн нийгмийн амьдрал тэр чигээрээ сүлэлдэн нийлэх зүг рүү нүүдэллэж явна. Даяаршил бол чухамдаа олон үндэстний соёл иргэншлийг хооронд нь хольж сүлж, дээжийг нь сорчилж байгаа өргөн цар хүрээний эвцэлдүүлэг юм байна аа.

Миний ойлгож байгаагаар сэтгүүл зүйн бүтээлийн нэвтрэх чадварыг нөхцөлдүүлж байдаг гол шаардлага нь утга гүн, үг цөөн, бичлэг уран, санаа саруул, зорилго гэгээн, баримт үнэн байх явдал аа.

ОРЧИН ҮЕ СЭТГҮҮЛЧДЭЭС ЯМАР БҮТЭЭЛ НЭХЭЖ БАЙНА ВЭ?

Өнөөдөр хүн төрөлхтөн яарч байна. Түүний дотор монголчууд их яарч байна. Уужуу тайван налайж суух нь тэр чигээрээ алдагдал, ялагдал, сүйрэл, хоцрогдол болжээ. Хэн сайн сайхан амьдрахыг хүснэм, тэр яарч амжих хэрэгтэй. Цаг бол алт гэдэг байсан. Тэр ойлголт хуучирсан. Цаг бол одоо амь нас болж. Иймээс уншигчдад хоёрыг биш нэгийг унших хэрэгцээ гарч байна. Сайхан зүйлийн тухайг нь уншихдаа сайхныг өөрийн нь нэгэн зэрэг мэдэрч ухаан нэмэхийн хамт сэтгэл ариусах шаардлагатай тийм эрин цаг иржээ.

Унших тусам үг, өгүүлбэр бүрийн чанадаас шинэ ертөнц нээгдэж байхыг уншигчид хүлээж байна. Өмнө нь бодож үзээгүй шинэ ухаарал, учир явдлын нууц далд холбоо хэлхээс, өөр хэн ч анхалж хэлээгүй уран гоё хэллэг, эвдэрч талхигдаагүй онгон санаа бодол, яруу сайхан мэдрэмж өгч чадах мэдээ, бичил нийтлэл, туурь, эссэ, бэсрэг эргэцүүлэл, таталбар, маягийн бүтээл үнэд орж байна. Тийм л нийтлэл мөн байвал тэр нь сэтгүүлчийнх ч байна уу, уран зохиолчийнх ч байна уу ялгаа юун билээ.

СЭТГҮҮЛ ЗҮЙН БҮТЭЭЛД ЯМАР ШИНЭ ХАНДЛАГА АЖИГЛАГДАНА ВЭ?

Сүүлийн үед манай сэтгүүл зүйд уран сэтгэмжийн охь болсон бичил нийтлэлүүд элбэгшиж шинэ хандлага ажиглагдаж байна. Төвөггүй жижигхэн, харахын зуурт уншигддаг мөртлөө тархинд оронгуутаа тахлын нян шиг эсөж үрждэг, гэгээн амьдрал руу түлхэж чаддаг бичил нийтлэлийн эрин цаг ирж байгаагаар төсөөлж болно буй заа.

Сэтгүүл зүйн бичил нийтлэлийн уран тансаг бүтээл гэдэг нь минийхээр бол уран зүйрлэлтэй, зураглалтай, энгийн сайхан хүүрнэлтэй, илүү дутуугүй оносон цөөн үгтэй, шинэ мэдлэг эргэцүүлэл нь хурц тод, хүмүүст очих нөлөөлөл (зорилго) нь ариун гэгээлэг байх хэмжээс юм.

Нэртэй сайн сэтгүүлчдийн ихэнх нь уран зохиолчид байсан, байгаа. Бас ирээдүйн том том зохиолчид анх сэтгүүл зүйн зовсон сүүгээр амлаж хөлд орсон нь цөөнгүй. Манайд ч гадаад оронд ч ийм л түүх бий. Тэд махан баримтыг хагсран буйлуулж уран үг ургуулахдаа гарамгай. Бичихдээ мэргэн зүйрлэл, ил тод зураглал, уран хэллэгээрээ давамгайлсан уншигчдыг өөртөө татдаг. Энэ бүх чанаруудыг (ур чадварыг) уран зрхиол бичдэггүй сэтгүүлчид ч сурч эзэмших шаардлагатай.

ЗҮЙРЛЭЛ ХЭРЭГТЭЙ ЮУ?

Онц чухал хэрэгтэй. Зүйргүй үг, зүйдэлгүй дээл үгүй ээ. Монгол ардын цэцэн ухааны айлдварт ийм үг бий. Бүхнийг зүйрлэлээр илэрхийлж болох нь ээ. Зүйрлэл бол аливааг цаг хэмнэж, алдаа багатай таних арга. Сайн оносон зүйрлэл нь бичсэн атлаа зурсан юм шиг, далд мөртлөө ил юм шиг харуулдаг ид шидтэй. Тийм учраас уран зохиолд ч, сэтгүүл зүйд ч хэрэглэдэг. Сэтгүүл зүйд зүйрлэлийн үүрэг харьцуулшгүй их боллоо. Сүүлийн үед оюуны залхуурал ихэсч, ялангуяа танин мэдэхүйн салбарт бэлэнчлэх, хялбарчлах хандлага газар авч байна. Сүүлийн үед нэгнийхээ нэрийг ч бүтнээр нь хэлэхээс залхуурдаг болж. Аагаа, Эзэгэ, Баагаа, Таагаа, Өөгөө, Төөгөө, Гоогоо, Доогоо гэхчилэн дууддаг болж.

Ийм нөхцөлд мэдэхгүйг мэддэгээр нь, танихгүйг таньдагаар нь, үзээгүйг үзсэнээр нь, далдыг илээр нь зүйрлэхэд илүү дөт хүнд хүрдэг учраас уншигчдын залхуу ухааныг оюунжуулахад зүйрлэл шиг нөлөөтэй арга ховор болжээ. Оновчтой мэргэн зүйрлэл бүхнийг ялан дийлнэ.

Харьцуулсан зүйрлэл нь ихэнхдээ хэмжүүрийн үүрэгтэй. Ирэх өвөл хүйтэн өвөл болно гэвэл ерөнхий мэдээлэл. Ирэх өвөл өнгөрсөн өвлөөс хүйтэн болно гэвэл тодорхой мэдээлэл. Ирэх өвөл сүүлийн гучин жилд болоогүй хүйтэн болно гэвэл сэрэмжлүүлэх мэдээлэл. Ийм мэдээлэл нь сүйрэхийг хүсээгүй бүхнийг хөдөлгөөнд оруулна.

УРАН ДҮРСЛЭЛИЙН ТУХАЙД ЮУ ХЭЛЖ БОЛОХ ВЭ?


Сэтгүүл зүйн өнцгөөс харваас зураг дүрс бол мэдээлэл. Мэдээлэл учраас засаглал. Тэр бээр шинийг мэдүүлж ухаан нэмнэ. Сонирхол татаж, сэтгэл хөдөлгөнө. Арга нь олон. Зураасаар, будгаар, гэрэл сүүдрээр гэхчилэн. Уран зохиол, сэтгүүл зүйд зураг дүрслэл хэрэгтэй. Будгаар бус үгээр зурдаг онцлогтой.

Гоё сайхныг уншигчид ухаанаараа уншдаг. Гайхамшиг бол сэтгэлээрээ уншдаг. Гайхамшиг бүхэн тухайн хүний сэтгэлийн дотоод туршлага дээр суурилж уншигдана. Уншигдана гэдэг нь мэдрэгдэнэ гэсэн үг. Дашдоржийн Нацагдоржийн “Хөдөө талын үзэсгэлэн” уран зураглал бол гайхамшиг. Түүнийг зөвхөн монгол хүн л гайхамшигаар нь мэдэрч чадна. Сэтгүүл зүйд сонирхолтой олон мэдээллээр ямар нэгэн бүхлийг нэгтгэн зураглах, ямар мэдээлэлд орсон баримт үйл явдлыг тухайлан дүрслэж зурах зэрэг ялгаанууд бий. Үгийн зураглалд зүйрлэл, адилтгал, харьцуулалтыг хавсарган ашиглах нь элбэг байдаг.

Нууцын тухай зах зухаас нь

Хууль зүйн ойлголт талаасаа нууц гэдэг нь хэрвээ задруулбал тухайн нууцыг эзэмшигчийн аюулгүй байдалд хор хохирол, аюул занал, учруулж болох мэдээллийг гэж ойлгодог. Манай Монгол Улсын хууль тогтоомжоор нууцыг ерөнхийд нь төр, байгууллага, хувь хүний нууц гэж 3 төрөлд ангилж үзэж байна. Эдгээрийг тус бүрт нь хуулиар хамгаалж

“Төрийн нууцын тухай”, “Төрийн нууцын жагсаалт батлах тухай”, “Байгууллагын нууцын тухай”, “Хувь хүний нууцын тухай” гэсэн төрөлжсөн хуулиудыг батлан гаргаж дагаж мөрдөж байгаа бөгөөд мөн зарим хуулиудад нууцын тухай заалтууд орсон байдаг.



Төрийн нууцын тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиуд, мөн бусад хуулиудад орсон төрийн нууцтай холбоотой заалтууд нь төрийн нууцад хамаарах, хамаарахгүй мэдээллийн зааг хязгаарыг гаргаж өгсөн нь төрийн нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг хэн нэгэн өөрийн хууль бус үйлдлээ олон нийтээс нууж хааЕын тулд төрийн нууц гэсэн халхавчин доор хийхээс урьдчилан сэргийлсэн байдал юм. Мөн “Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль”-иар нийт 59 төрлийн мэдээллийг төрийн нууцад хамааруулсан байдаг.

Байгууллагын нууцын хувьд тухайн байгууллага өөрөө аливаа мэдээллийг нууцад хамааруулах шийдвэрээ гаргадаг. Мөн байгууллагын нууцад хамааруулж болохгүй мэдээллийн хүрээг хуулиар тогтоосон байдаг. Үүнд тухайн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл, тухайн байгууллагын мэдэлд байгаа бөгөөд хадгалалт, хамгаалалтын горим нь зөрчигдсөн тохиолдолд хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээлэл, гэмт хэргийн тухай болон нийтэд мэдээлэхээр хуульд заасан бусад мэдээлэл гэж “Байгууллагын нууцын тухай хууль”-д заасан байдаг. Энэ нь мөн л дээрхийн адил хэн нэгний хууль бус үйл ажиллагааг нууц гэдэг нэрийдлээр бусдад мэдэгдэхгүй байх гэсэн зорилгын эсрэг буюу хязгаарлалтыг хязгаарласан заалтууд юм.

Хувь хүний нууцын тухай хуулиар хувь хүний нууцыг:

- o Эрүүл мэндийн нууц,
- o Эд хөрөнгийн нууц,
- o Гэр бүлийн нууц,
- o Захидал харилцааны нууц,
- o Бусад гэж ангилдаг.

Эдгээр төрийн, хувь хүний, байгууллагын гэх нууцуудыг задруулсан зарим үйлдлийг Монгол Улсын Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцож ял шийтгэхээр заасан байдаг. Яагаад “зарим үйлдлийг” гэж байна вэ гэвэл нууц задруулсан бүх хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэж үздэггүй. Өөрөөр хэлбэл Эрүүгийн хуулийн 87 дугаар зүйлд “Төрийн нууц задруулах” гэмт гэсэн гэмт хэргийн тухай заасан байдаг. Энэ зүйл зээр та бүхэнд тайлбарлахыг хичээе.

“Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг **итгэмжлэгдэн хариуцсан буюу албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд**

задруулсан нь эх орноосоо урвах, тагнуул хийх гэмт хэргийн шинжгүй бол ...” гэж томъёолсон байна. Эндээс харахад төрийн нууцыг задруулсан хүн болгон энэ гэмт хэргийн субъект болохгүй, харин зөвхөн өөрийн хашдаг албан тушаалын онцлогоос шалтгаалан энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцогдож ял шийтгэгдэх үндэслэлтэй нь харагдаж байна.

Мөн бүх нууц задруулсан хэрэгт энэ мэтчилэн зөвхөн тусгай субъект яллагдана гэж ойлгож бас болохгүй. Өөрөөр хэлбэл Эрүүгийн хуулинд заасан “Иргэний захидал харилцааны нууцын халдашгүй байдлыг зөрчих” гэмт хэрэгт энэ гэмт хэргийн субъект нь гэм буруутай хэн ч байж болох юм.

Ардчилсан нийгэмд нууцыг аль болох боломжтой хэмжээнд хүрээг нь хумиж мэдээллийн эрх чөлөөг тэргүүн ээлжинд тавихыг чухалчилдаг. Түүнчлэн ардчилал, эрх зүй нь орчин үеийн либерал үзэл санаанд нийцсэн улс орнуудад нууцыг тэр чигт нь ямар ч гарц байхгүй хадгалаад байхыг гол болгодоггүй. Өөрөөр хэлбэл нууцыг ямар өнцгөөс нь харах, мөн задруулж болох шалгууруудыг тогтоож өгсөн байдаг ажээ. Энэ нь гэвэл нууцыг хэн, хэзээ, хэрхэн ямар үндэслэлээр задруулахыг тодорхой хуульчилах шаардлага ардчилсан нийгмийг хөгжүүлэхийг зорьж байгаа улсуудад чухлаар хөндөгддөг сэдэв болдог байна. Мөн зөвхөн хууль зүй, эдийн засаг, нийгмийн хөгжил нь заавал дорой буурай улсууд байгаа төдийгүй мөн барууны хөгжингүй улс орнууд хүртэл энэ байдлын төлөө дуу хоолойгоо нэгтгэж байгаа билээ.

Нууц мэдээллийг задруулах үндсэн шалгуурыг олон улсын түвшинд:

- o Уг мэдээлэл хуульд заасан хууль ёсны зорилгод хамаатай байх ёстой
- o Мэдээллийг задлах нь дээр дурдсан зорилгод занахийлж, ихээхэн аюул учруулахаар бол,
- o Дээрх зорилгод учрах аюул занал нь тухайн мэдээллийг нээлттэй болгох олон нийтийн ашиг сонирхлоос илүү их бол гэсэн гурван шалгууртай байхаар үзэж өөр өөрийнхөө улс орнуудын хууль тогтоомжуудад тусгаж өгөхийг дэлхийн бүх улс орнуудад уриалдаг байсан бол сүүлийн үед:
- o Хэдийгээр олон нийтийн мэдэх эрхэд нийцүүлэн нууцад хамаарах мэдээллийг задруулах нь чухал гэж үздэг байсан ч гэсэн тэрхүү мэдээллийг задруулснаас үүсэх үр дагавар нь задруулаагүй байснаас илүү сайн үр дагаварт хүргэхгүй бол задруулахгүй байх нь чухал гэсэн дөрөв дэх шалгуурыг харгалзан үзэх шаардлагатай гэж үздэг болсон байна.

Тэд сонины тухай

Түрүүч нь өмнөх дугаарт

Сонины үүрэг /Дэлхийн Сонинуудын Холбоо/

Дэлхийн улс орнуудын нөлөө бүхий өдөр тутмын сонины эрхлэгчдээс Дэлхийн сонинуудын холбооноос дараах зургаан асуултанд хариулт авчээ. Асуултуудыг тодруулбал:

1. Сонины нийгэмд гүйцэтгэх үүрэг

Танай сонин нийгэмд ямар үүрэг гүйцэтгэдэг гэж үзэж байна вэ?

2. Хэвлэл мэдээллийн бусад хэрэгсэлтэй харьцуулах нь

Өрсөлдөгч хэвлэл мэдээллийн хэрэгслээс танай сонин юугаараа ялгарах онцлогтой вэ?

3. Сонины давуу тал

Олон түмэнд мэдээ үйлчилгээг хүргэхэд сонины телевиз, радио, интернэт зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээс ялгарах давуу тал нь юу вэ?

4. Популизмын хандлага

Сүүлийн үед хэвлэл мэдээллийн хэрэгслүүд сониныхоо хэвлэлтийн тоог нэмэгдүүлэхийн тулд нийгэмд тулгарсан чухал асуудалд илүү анхаарал хандуулах биш телевиз, спортын одод, нэр хүндтэй хүмүүсийн тухай мэдээ материал түлхүү нийтэлж популизмын чиг хандлагатай болж байна хэмээн шүүмжлэлд өртөх боллоо. Энэ талаарх таны бодол?

5. Уншигчдын тоог ихэсгэх

Сонинууд уншигчдын тоог нэмэгдүүлэхийн тулд юуг хийх хэрэгтэй гэж та үзэж байна вэ?

6. Нөлөөг нэмэгдүүлэх

Тухайн үйлчилж байгаа нийгэмдээ нөлөөлөх, байр сууриа нэмэгдүүлэхийн тулд сонинууд юу хийх хэрэгтэй гэж та үзэж байна вэ?

ТАЙЛБАР, ДҮН ШИНЖИЛГЭЭ БОЛ СОНИНЫ ДАВУУ ТАЛ

Энэ дугаарт Чилийн “Меркурио” сонины редактор Фелипп Эдвард дель Риогийн хариултыг нийтэллээ.

1. Нийгэмд гүйцэтгэх үүрэг

Хүн амын мэдээлэл хүртэх эх үүсвэр тэлж буй энэ ертөнцөд өсөн нэмэгдсээр байгаа “түүхий” мэдээллийг эмх цэгцэнд нь оруулахыг бид чармайж байна. Бидний гол баримталж байгаа зарчим бол өөрийн вэб хуудас болон бусад электрон хэрэгслээр маш хурдацтай тархсан мөн хэдийнэ олон нийтэд хүрсэн мэдээллийг нийтлэх бус өчигдөр болсон үйл явдал манай нийгэм, уншигчдад ямар нөлөөтэй юм бэ гэдэгт дүн шинжилгээ хийж тайлбарлан хүргэхийг зоридогт оршино.

2. Бусад хэвлэл мэдээлэлтэй харьцуулах нь

Телевизийн шуурхай бас хөдөлгөөнт дүрс нь хүнд илүү хүрдэг. Түүнчлэн хүн хүссэн хүсээгүй ажилдаа ирж, буцах замдаа радиогийн мэдээллийг сонсдог. Харин бидэнд энэ дүр зургууд мөн агаарын долгионоор дамжуулах боломжтой цөөн хэдэн баримтын утга учрыг тайлбарлах цаг хугацаа болоод орон зай байдаг. Тэд мэдээллийг дамжуулж, бид үйл явдлын мөн чанарыг ойлгоход тусалдаг. Гэхдээ бусад электрон хэрэгслийн адилаар бид уншигчдаа хөдөлгөж, зугаацуулж, сорьж, туршиж, гэнэтийн бэлэг барьдаг нь тодорхой.

3. Сонины давуу тал

Манай гол давуу тал бол цаг хугацаа. Хорин дөрвөн цагийн дотор бид үйл явдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулж, шинжээчдийн саналыг авахын зэрэгцээ мэдээ нийтлэлээ хүснэгт, зургаар баяжуулж агуулгыг нь улам гүн гүнзгий, цогц илэрхийлэх боломжийг ашигладаг.

4. Популизмын хандлага

Чанартай сонинууд уншигчдынхаа тоог нэмэгдүүлэхийн тулд хүмүүсийн амьдралыг дээшлүүлж, нөлөөлөх үйл явдлын үнэн мөн чанарыг олж харах, бодож тунгаах бололцоо олгосон мэдээ нийтлэх зэрэг эрхэм зорилгоосоо ямар ч үед ухрах шаардлагагүй юм. Шувууны томууны тархалт, боловсролын салбарыг дээшлүүлэхэд чиглэсэн эрэн сурвалжлах чухал мэдээ материал нь зарим үед Элизабет Харлийн хүүхдийн эцэг хэн бэ? Жүжигчин Хью Грант одоо хэр нь яагаад гэрлэдэггүй вэ? гэх зэрэг мэдээ нийтлэлтэй харьцуулахад агуулгын хувьд түүхий болсон нь ажиглагддаг.

Телевиз, спортын одууд сонины борлуултад нөлөөлдөг ч, ийнхүү борлуулахад сонины чанар тийм ч чухал биш байдаг. Хэрэв энэ сонинууд одуудын талаар төдийлөн сонирхдоггүй уншигчдын гарт очвол сонины хамаг хүч нөөц бололцоог шавхдаг үндэсний, улс төрийн, нийгмийн асуудлаарх мэдээ, нийтлэл анхааралд нь өртөхгүй орхигдоно. Гэхдээ энэ нь зугаа цэнгэл болон спортын салбарыг үл ойшоох ёстой гэсэн үг биш юм. Бид Иракийн дайн, улс төрийн мэтгэлцээнийг хэрхэн сурвалжилдаг яг л тэр хэмжээгээр энэ салбарын мэдээ сурвалжлагыг хийх хэрэгтэй.

5. Уншигчдын тоог нэмэгдүүлэх нь

Хамааралтай холбоотой байх хэрэгтэй. Улс төр нийгмийн асуудлаарх мэдээ сурвалжлага нь хуурай, уйтгартай байх ёсгүй. Одоогийн хэрэглэгчдээ хадгалж шинэ хэрэглэгчдийг татахын тулд бид ямагт сэтгүүлзүйн чанарыг дээшлүүлж байх хэрэгтэй. Телевиз, радиогоор уншигч сонсогч хэдийнэ хүлээж авсан мэдээн дээр өөрсдийн байр суурь, үнэтэй дүн шинжилгээ хийхгүй бол бид өөрсдийн ирээдүйг эрсдэлтэй байдалд оруулж байгаа хэрэг юм. Мэдээний агуулгыг баяжуулахад сэтгүүлчдийн ур чадвар, авьяас асар их чухал байдаг. Хэрэв бид шинэ уншигчдийг татаж тэдэнд чухал зүйлийг хэлэхийг хүсч байгаа бол редакцдаа чадварлаг сайн баг бүрдүүлэх хэрэгтэй. Шинээр ирж байгаа сэтгүүлчид нь өмнө редакцид байсан хүмүүсээс илүү боловсролтой байх ёстой. Тэд одоо ажиллаж байгаа сэтгүүлчдээ сургаж тусалдаг байх нь чухал юм.

Мэдээний байршил, макет, график дүрслэлд мэдээний агуулгыг боловсруулж байгаатай адил ач холбогдол өгч, цаг зав зарцуулагддаг гэдгийг анхаарах хэрэгтэй. Энэ бүхэн нь харааны дүрс зонхилж байгаа энэ ертөнцөд чухал бөгөөд ялангуяа залуусыг татахад ихээхэн ач холбогдолтой юм.

6. Нөлөөгөө ихэсгэх

Дээрх асуулттай ижилхэн юм. Нөлөөлж чаддаг байхын тулд бид унших хэрэгтэй. Бидний хийснийг уншдаг байхын тулд бид хэлэх юмтай байх нь чухал юм.

Эх сурвалж

1. “Сонины гүйцэтгэх үүрэг”
Дэлхийн сонингуудын холбооны стратеги илтгэл
www.futureofthenewspaper.com

СЭТГҮҮЛЧДЭД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ

Финландын Сэтгүүлчдийн холбоо 1991 оны 11-р сарын 2-нд уг зөвлөмжийг сайшааж, 1992 оны 1-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болгосон байна.

Өмнөтгөл

Сэтгүүл зүйн үйл ажиллагааны үндэс - Дэлхий дахинд болон нийгэмд болж байгаа үйл явдлын талаар баттай, бүрэн төгс, чухал мэдээлэл олж авах иргэдийн эрхийн салшгүй хэсэг юм.

Сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй нь хүний үндсэн эрх, эрх чөлөө, ардчилал, дэлхий болон олон улсын харилцан ойлголцол гэх мэт үнэт зүйлийг хүндэтгэхтэй салшгүй холбоотой билээ.

Сэтгүүлч хүрээлэн буй орчны талаар хүлээсэн үүргээ ухамсарлаж, энэ чиглэлд хамаатай асуудлыг хэлэлцүүлэхээр өргөн дэвшүүлдэг байх ёстой.

Чанартай сэтгүүл зүйн практик нь нийгэм болоод сэтгүүлчийн үг хэлэх эрх чөлөөг хязгаарладаггүй. Чанартай сэтгүүл зүй нь харилцаа холбооны бодлого, зарчмын талаарх хариуцлагыг агуулсан байх бөгөөд мэдээлэл чөлөөтэй солилцох, харилцан ярианы хөгжилд түлхэц болох ёстой.

Энэ зөвлөмж нь хэвлэл мэдээллийн аль ч хэрэгслийн сэтгүүлчид хамаатай болно. Мэдээж хэрэг сэтгүүлчид өдөр тутам тулгарч байгаа бэрхшээлүүдийг шийдэх санал гаргаж чадахгүй. ХМХ-ийн асуудал эрхэлсэн зөвлөлийн зарчмын шийдвэр мэдэгдэл нь энэ зөвлөмжийг нөхөж, тайлбарлана.

Чанартай сэтгүүл зүй гэдэг нь сэтгүүлч мэргэжлийн үйл ажиллагаагаа эрхлэх явцад тулгарч байгаа гол хуулиуд, хууль эрх зүйн акт, олон улсын гэрээ хэлэлцээрт захирагдахыг хэлнэ.

Мэргэжлийн статус

1. Харилцаа холбооны агуулгын бүх шийдвэрийг сэтгүүл зүйн шийдвэрийн үндэст тулгуурлан гаргана. Ямар ч тохиолдолд редакцийн хүрээнээс гадна байгаа хэн нэгэнд шийдвэр гаргах эрх мэдлийг олгож болохгүй.

2. Сэтгүүлч юун түрүүнд сонсогч, үзэгч, уншигчдын өмнө үүрэг хүлээнэ. Сэтгүүлч хувийн ашиг сонирхолд тулгуурлан мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулж болохгүй.

3. Сэтгүүлч мэдээллийг хязгаарлах, энэ мэдээлэл хэрэгтэй этгээдэд түүнийг дамжуулахад саад хийх зорилготой бүх хэлбэрийн дарамт, шахалтыг сөрөн зогсох ёстой бөгөөд ийм эрхтэй.

4. Сэтгүүлч ашиг олохын тулд мэргэжил болоод төлөөлж буй ХМ-ийн байгууллагыг ашиглаж болохгүй. Энэ нь тухайн сэтгүүлчийн хараат бус байдал түүнчлэн мэргэжлийн ёс зүйн зарчмын дагуу ажиллахад нь сөргөөр нөлөөлж болзошгүй.

5. Сэтгүүлч өөрийн хувийн итгэл үнэмшил болоод шударга сэтгүүл зүйн зарчмаас ангид ажиллах ёсгүй. Тэрээр энэ зарчимд үл нийцэх даалгаврыг биелүүлэхээс татгалзах эрхтэй.

6. Чанартай сэтгүүл зүй нь бусад зохиолчдын ажилд хандахад саад болдоггүй. Энэ нь зохиогчийн эрхийн тухай бус ёс зүйн дүрмийн тухай буюу мэдээллийг ашиглахдаа эх



сурвалжийг зайлшгүй дурдаж байх, тухайлбал мэдээллийг хаана нийтэлсэн, хэний бүтээл зэргийг дурдаж байх гэсэн үг юм.

7. Сэтгүүлч бүх төрлийн далд зар сурталчилгаанаас зайлсхийх ёстой. Тэрээр арилжааны ашиг сонирхолтой байж болзошгүй материалд шүүмжлэлтэй хандах хэрэгтэй. Мэргэжлийн онцгой үндэслэлтэй нөхцөлд л уг материалыг нийтэлнэ. Сурталчилгаа болон редакцийн материалыг хооронд нь нарийн тусгаарласан байна.

Баттай мэдээлэл

8. Сэтгүүлч өөрийн ажлын хүрээнд бодитой, чухал, баттай мэдээлэл дамжуулахыг хичээх хэрэгтэй.

9. Сэтгүүлч мэдээллийн эх сурвалжид шүүмжлэлтэй хандах ёстой. Зөрчилтэй, чухал материал бэлтгэх үед энэ нь ихээхэн ач холбогдолтой. Тухайн тохиолдолд мэдээллийн эх сурвалж нь хувийн ашиг сонирхолдоо хөтлөгдсөн эсвэл хэн нэгэнд хор хохирол учруулах бодолтой байж болох юм.

10. Баримттай мэдээллийг сайтар шалгасан байна. Өмнө нь нийтлэгдсэн материалыг ч гэсэн сайтар нягтлан шалгах ёстой.

11. Сэтгүүл зүйн материалын баримтыг үзэл бодлоос мөн баримттай мэдээллийг дүгнэлтээс ялгах боломжийг олон нийтэд олгох ёстой. Энэ зарчим нь сэтгүүлчийн найруулан бичих хэв маягаа сонгоход нь хязгаарлалт болох ёсгүй.

12. Гарчиг, гэрэл зургийн гарын үсэг, шигтгээ, товч тайлбар зэрэг бусад дагалдах материал нь нийтлэлийн агуулгатай нийцэж байх ёстой.

13. Дүрслэл болон аудио материалыг зөв ашиглах ёстой. Баримтат материал хаана дуусч, зохиогчийн өгүүлэл хаанаас эхэлж байгааг давхар утга агуулалгүй үзэгч болоод уншигчдад шууд ойлгуулах.

Мэдээлэл олж авах

14. Мэдээллийг шударга, нээлттэй арга замаар олж авна. Нийгэмд онцгой ач холбогдолтой мэдээллийг шударга арга замаар олж авах боломжгүй тохиолдолд мэдээлэл олж авах онцгой аргыг зөвтгөж үзнэ.

15. Ярилцлага өгч байгаа хүн түүний өгсөн мэдээлэл ХМ-ийн аль хэрэгслийн ямар хэсэгт гарахыг мэдэх эрхтэй. Ярилцлага өгч байгаа хүнд түүний өгсөн мэдээллийг ярилцлага хэлбэрээр эсвэл материалын фон хэлбэрээр ашиглах саналыг өөрөөс нь асуух нь мэргэжлийн нэг шинж чанар гэж үздэг.

16. Ярилцлага өгсөн хүн баримт болон хэлж ярьсан зүйлтэйгээ холбоотойгоор тухайн материалтай нийтлэгдэхээс нь өмнө танилцах хүсэлт гаргавал сэтгүүлч үүнийг нь биелүүлнэ. Гэхдээ материалыг нийтлэх шийдвэр гаргах сэтгүүлчийн эрхэнд хэн ч халдах ёсгүй.

17. Мэдээллийн эх сурвалжийг хамгаалах ёстой. Баттай мэдээлэл өгсөн хүний мэдээллийг зөвхөн өөрөө зөвшөөрсөн тохиолдолд л дэлгэж тавина. Сэтгүүлчийн ажилладаг ХМХ-д нууц нэрээр материалаа нийтлүүлдэг хүнд ч гэсэн энэ нь хамаатай.

Эх сурвалж: Фонд защиты гласности "Сэтгүүл зүйн өөрийн зохицуулалт, оршин тогтнох туршлага болон бэрхшээл"

Далайд дусал

БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ САЙЖРУУЛАХ НЬ**Залуу уншигчид - Тэдний ирээдүй бол таны бизнес**

40 гаруй жилийн турш сонинууд Сониныг Боловсролд Ашиглах /СБА/ төслүүдийг дэмжиж ажилласан ч залуу болон ирээдүйн уншигчдаа бүрэн татаж чадаагүй л байна. Энэ төслүүдийн ихэнх нь юунд чиглэсэн нь тодорхойгүйгээс сонинууд залуусыг татах боломжийг алдсаар байдаг.

Хэрэглэгчдийн аясыг дагахын оронд тэдэнд сонин унших дадал суулгах замаар ирээдүйн уншигчдаа бэлтгэж, тэдний анхаарлыг татах дорвитой алхам хийх хэрэгтэй байна.

Сонины эерэг дүр төрхийг бий болгох - өсвөр насныханд ямар нэг байдлаар уг сонинтой холбогдох хүсэл төрүүлэх. Үүнийг өөр сонголт бүхий шинээр бүтээгдэхүүн гаргахтай адилтган үзэж болохгүй юм. Хэвлэл мэдээллээр хаччихсан тухайн нийгэмд сонины салбарынханд хурдацтай буурч буй хэвлэлийн тоогоо нэмэгдүүлэхэд жил ирэх тусам төвөг учирч байна. Хэвлэлтийн тоо ийнхүү буурсан шалтгаан нь уншигчид цөөрсөнтэй холбоотой гэж саяхны судалгаагаар нотложээ.

Өндөр настай уншигчид өөд болсноос эсвэл хүн ам зүй, хүн амын тоо өөрчлөгдсөнөөр уншигчдын тоо буураагүй. Сонинууд дараагийн үе буюу хүүхэд залуусыг татаж чадахгүй байгаа нь уншигчдын тоо буурахад нөлөөлж байна. Энэ салбар ашигтай хэвээр байгаа болохоор сонины удирдлагууд залуу уншигчдыг татах шинэлэг арга хэмжээ яаралтай авахгүй байгаагаас сонин нь хүүхэд залуусын хувьд үнэ цэнэгүй, ач холбогдол багатай зүйл болж хувирна. Энэ хэвээр үргэлжилбэл сонинг үнэлэх өсвөр үеийнхний үнэлэмж буурч, сонины агуулга нийтлэл нь тэдний амьдралд тодорхой үүрэг гүйцэтгэхгүй гэсэн итгэл үнэмшлээр насанд хүрэх юм.

Мэдээллийн хомсдол

Өвхөн сонинууд өсвөр үеийнхэн, залуусыг татаж чадахгүй байгаа бус мэдээллийн ертөнц тэр чигээрээ энэ зах зээлийг эзэмшихэд ихээхэн бэрхшээлтэй тулгарч байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд мэдээллээс илүү зугаа цэнгээнд түлхүү ач холбогдол өгөх болсон, уншигчдын анхаарал төвлөрөх хугацаа богиносон төдийгүй, хэдийгээр мэдээлэл хүртэх боломж өнөө үед улам нэмэгдсэн ч одоогийн залуусын шим ертөнцийн талаарх мэдлэг өмнөх үеийнхнээс хангалтгүй байна.

Өсвөр насныхан цаг зав багатайгаас энэ талаарх мэдлэгээ дээшлүүлж чаддаггүй хэрэг биш юм. "СМС Интернэйшнл" 1996 онд Их Британийн өсвөр насны 1000 орчим хүүхдийн дунд явуулсан судалгаагаар тэдний олонх нь мэдээлэл хүртэх асар их цаг завтай байдаг нь тогтоогджээ. Эдгээр хүүхдүүдийг идэвхжүүлэх л дутагдаж байгаа юм.

Тиймээс өсвөр насныхан, залууст чиглэсэн зарим үйл ажиллагаанд тодорхой нэг ахиц дэвшил гарч байна. Сониныг Боловсролд Ашиглах төсөл болон холбогдох гэрийн сургуулийн төслөөр дамжуулан хүүхдэд нөлөөлөх чадвартай багш, эцэг эх зэрэг насанд хүрэгчид хүүхдийг тогтмол сонин уншдаг дадалтай болгоход сонинг ашигладаг байна.

Сонин унших хүслийг яаж төрүүлэх вэ? Тэднийг хэрхэн сонин унших дадалтай болгох вэ?

Юун түрүүнд бид Сониныг боловсролд ашиглах уламжлалт аргаа орхиж болохгүй. Богино болон дунд хугацааны зорилтдоо хүрэх, хэвлэлтийн тоог нэмэгдүүлэх, орлогын шинэ эх үүсвэр олох зэрэгт СБА төсөл нь үр дүнгээ өгсөн хэвээр байх болно гэдгийг удирдлагууддаа ойлгуулах хэрэгтэй.

Гэхдээ эрхэм зорилгоо тодорхойлж, түүндээ хүрэхийг чармайх нь илүү чухал юм. Залуу уншигчдыг гурван үндсэн бүлэгт хувааж байна:

Огт сонин уншдаггүй: Тэднийг мартсан нь дээр. Амьдралынхаа туршид урцнаасаа цааш харах хүсэл энэ бүлгийн залуучуудад дуслын төдий л төрнө. Бид тэднийг төдийлөн татаж чадахгүйн дээр ихээхэн хөрөнгө мөнгө зарцуулаад эцэстээ үр өгөөж нь төдий л мэдрэгдэхгүй.

Үүрдийн уншигч: Тэднийг ч бас мартаж хэрэгтэй. Тэд бол ном, сонин, сэтгүүлийн баталгаатай хэрэглэгчид. Тэднийг зөвхөн идэвхжүүлэх арга хэрэгслээр татна. Ингэхдээ унших

дадал хэдийнэ суусан энэ хүүхдүүдийн сонирхлыг татахын тулд байнга анхаарал тавих хэрэгтэй.

Завсрын уншигч: Хамгийн олон хүүхдийг хамарсан энэ бүлэг нь хүн бүрийн хувьд онцгой чухал хэсэг юм. Тэдэнд чиглэсэн аливаа арга хэмжээг тэд эсвэл сонирхон хүлээж авна, үгүй бол зөвхөн тухайн үедээ мэдрээд тусгаж авалгүй өнгөрөөхийн завсарт буй уншигчид юм. Эхний хоёр бүлгийн хүүхдүүдэд СБА болон хүүхдийг бага наснаас нь ном сонин унших дадалтай болгох, гэр бүлийн аян, сурталчилгаа, залууст зориулсан сонины булангийн материалыг шог хошин өнгө аясаар илэрхийлж, тэднийг идэвхжүүлэх арга хэмжээг цаашид үргэлжлүүлэн авч байх хэрэгтэй.

Эдгээрээс сүүлчийн бүлэг нь хамгийн төвөгтэй. Эцэг эх, багш бусад нөлөө бүхий насанд хүрэгчид эхэн үедээ энэ бүлгийн хүүхдүүдэд хялбархан нөлөөлж чаддаг. Тэд өсч, томрох тутам үр нөлөө нь буурдаг байна.

Бид юу хийж чадах вэ?

СБА үйл ажиллагааг 15-аас доош насныханд авч хэрэгжүүлсээр байвал илүү тохиромжтой. Тухайлбал сонинг анги танхимд авчирч болно. Гэхдээ уншигч нь багш бус сурагч байна гэдгийг анхаараарай. Энэ үйл ажиллагаа нь тэдэнд хамаатай хошин өнгө аястай байх ёстой. Ном сурах бичгийг голдуу ангиараа уншдаг уламжлал бий. Багш, эцэг эхчүүдийг өөрсдийн бүтээгдэхүүн болох сонинг илүү их ашиглах хүсэл төрүүлэхийн тулд бид их зүйл хийх шаардлагатай байна.

- **Залуу уншигчдыг татахын тулд аль болох тааламжтай уур амьсгал бүрдүүлж албан ёсны бус харилцаа тогтоохыг эрмэлзэх хэрэгтэй.**
- **Багш, гэр бүлийн гишүүдийг сонины төслүүд болон аянд оролцохыг дэмжих**
- **Уншиж сурах үйл явцын зэрэгцээ бүтээгдэхүүний тодорхойлолтоо сайн боловсруулах**
- **Мэдлэгийг үнэ цэнтэй болгох. Хүн болгон өөрийн юу мэддэгээ харуулахыг хүсдэг. Тиймээс ч ухаан шалгасан нэвтрүүлгүүд нь олны дунд алдартай байдаг нь ойлгомжтой юм.**

Өсвөр насныхны гэр бүлийнхэнтэй нь илүү холбоо тогтоох хэрэгтэй. Амьдралын хэв маяг өөрчлөгдсөнөөр өрхийн гишүүд болоод тэдний ном, сонин унших дадал харилцан адилгүй байна.

Энэ хэсэгт хүүхдэдээ тус болох хүсэлтэй, сонины дэмжлэг авах бодолтой олон эцэг эх багтдаг. Өрхийн гишүүдийг хамтдаа ажиллаж, хамтдаа юм уншихыг нь дэмжсэн тусгай арга хэмжээ зохион байгуулж, гэр бүлийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх нь зүйтэй. Уншигчдын тохиромжтой цаг хугацаанд бүтээгдэхүүнээ хүргэх янз бүрийн арга хэрэгсэл, цаг хугацааг харгалзан үзэх хэрэгтэй.

Манай залуу уншигчид 15 нас өнгөрч, өсч томорсон хойно нь томчуудаас тэдэнд үзүүлэх үр нөлөө багасдаг болохоор энэ үед ятган үнэмшүүлэх өөр бүтээгдэхүүнээр орлуулах шаардлагатай.

Өнөөгийн залуусын чиг хандлагад нийцэж байх нь чухал. Тэдний аясыг дагахын оронд мэдээгээ сонирхолтой болгоход түлхүү анхаарч ажиллах хэрэгтэй. Залуустаа уулзах явцад олж мэдсэн чухал санаа бол зөвхөн сонины агуулга нийтлэлд гол учир байгаа юм биш сониндоо түгээх аргаа шинэчлэх, тухайлбал оюутны хотхон, хөдөлмөрийн бирж, олон нийтийн тээврийн хэрэгсэл, шөнийн клуб зэрэг залуус цугладаг газар шуурхай хүргэхэд анхаарч ажиллах хэрэгтэй. Өнөө үед бид тэдний амьдралын нэг хэсэг болж чадахгүй байна, гэхдээ бид үүнийг хийх хэрэгтэй.

Зохиогч Жорж Келли

Бизнес стратеги төлөвлөлтийн асуудлаар мэргэшсэн "СМС Интернэйшнл" байгууллагын захирал

Эх сурвалж

Уншигч хүүхэд залуусыг хэрхэн татах вэ?

Дэлхийн сонины холбооны стратеги илтгэл

www.futureofthenewspaper.com

Бэлтгэсэн: Г.Нарангарав